



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
НОРОВЛИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар А/36

Жаргалант

**Ажлын хэсэг томилох тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Эрүүл чийрэг Норовлинчууд дэд хөтөлбөрийн 3 дугаар зүйлийн 3.2.4.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Эрүүл чийрэг Норовлинчууд хөтөлбөр, Идэвхитэй хөдөлгөөн Эрүүл Хэнтийчүүд аяны хүрээнд нийтийн биеийн тамир, спортоор хичээллэгсдийг дэмжих, эрүүл амьдралын хэв маягийг дэмжиж, спортын идэвхийг нэмэгдүүлэх зорилгоор Аймгийн аварга шалгаруулах “Цэнгээнт бүжиг”-ийн тэмцээнийг 2026 оны 03 дугаар сарын 28, 29-ний өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Аймгийн аварга шалгаруулах “Цэнгээнт бүжиг”-ийн тэмцээнийг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч	Д.Шижирмөнх	Засаг даргын орлогч
Нарийн бичиг	Г.Тэргэл	Нийгмийн бодлогын мэргэжилтэн
	Г.Баатархуяг	Байгаль хамгаалагч
	Г.Мягмарцогт	Хэвлэл мэдээллийн ажилтан
	Ц.Жинжиймаа	ЕБС-ийн нийгмийн ажилтан
	Г.Ганцогт	ЕБС-ийн багш
	Г.Болд	Соёлын төвийн өвийн ажилтан
	О.Анужин	Соёлын төвийн бүжгийн багш
	С.Хүүхэндүү	ЭМТ-ийн нийгмийн ажилтан
	Э.Ижилцэцэг	ЭМТ-ийн нярав
	Б.Мягмардаш	ЗДТГ-ын үйлчлэгч
	Х.Солонго	Мандах клубын гишүүн
	Х.Баярмандал	Мандах клубын захирал

3. Ажлын хэсгийн төлөвлөгөөг гарган 2026 оны 03 дугаар сарын 25-ны дотор танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Д.Шижирмөнх)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ө.ДАВААЖАРГАЛ

